



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/118

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит IX хуралдааны 05 дугаар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Нийтийн номын сангийн сан хөмрөгийн баяжилтыг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах үйл ажиллагаанд 10,000,000 (Арван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 10,000,000 (Арван сая) төгрөгийг Засаг дарга дансны аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тусгагдсан зарим арга хэмжээг санхүүжүүлэх зардлаас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Зардлыг зориулалтын дагуу зарцуулахыг аймгийн Нийтийн номын сангийн захирал (Э.Даваачулуун), нягтлан бодогч (Д.Энхсайхан) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН